



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/173

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 6 дугаар хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Онцгой байдлын ерөнхий газар болон салбар нэгжийн хугацаат тайлан мэдээг тайлагнах, дүгнэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Хугацаат тайлан, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын талаарх мэдээг үнэн зөв гаргаж хүргүүлэх, нэгтгэн боловсруулах, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч журмыг хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /хурандаа Л.Болдбаатар/-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны А/494 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

00001911

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн
Д/АЗ дугаар тушаалын хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН САЛБАР, НЭГЖИЙН ХУГАЦААТ ТАЙЛАН МЭДЭЭГ ТАЙЛАГНАХ, ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт явц, үр дүн, аврах, гал түймэр унтраах техник, багаж хэрэгслийн хангалтын талаарх тайлан мэдээ болон гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдол, Улсын нөөцийн бараа материалын хөдөлгөөнийг нэгдсэн хэлбэрт оруулан нарийвчлан бүртгэх, цэгцтэй мэдээллийн санг бүрдүүлэх, Засгийн газар, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагыг үнэн зөв, бодит тайлан мэдээгээр хангах зорилготой.

1.2 Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газар, Шадар сайдын болон Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал, шийдвэр, албан даалгавар, үүргийн хэрэгжилт, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайлан мэдээ, гаргахдаа энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Мэдээ, тайлан гаргах ажлын зохион байгуулалт

2.1 Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүд Онцгой байдлын ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг улирал, хагас жилээр сүүлийн сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн биелэлтийг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 37 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу гаргаж, Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид цахимаар болон албан бичгээр ирүүлнэ.

Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж тайланг нэгтгэж, хагас жилийн биелэлтийг 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн биелэлтийг 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хүргүүлнэ.

2.2 Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд энэхүү журмын хавсралтад заасан маягт хүснэгтийн дагуу мэдээг Онцгой байдлын ерөнхий газарт заасан хугацаанд цахим болон албан бичгээр ирүүлнэ.

2.3 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалт тус бүрийг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд зохион байгуулж, хэрэгжилтийг 5, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын загвар Маягт-ЗУГ-1 хүснэгтийн дагуу гаргаж, Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид цахимаар ирүүлнэ.

Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж тайланг нэгтгэж, хагас жилийн биелэлтийг 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн биелэлтийг 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хүргүүлнэ.

2.4 Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүд сарын ажлын тайланг сар бүрийн сүүлийн ажлын өдөр Маягт-ЗУГ-2 хүснэгтийн дагуу гаргаж, Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид цахимаар ирүүлнэ.

Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж тайланг нэгтгэж, дараа сарын 05-ны өдрийн дотор Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт албан бичгээр болон цахимаар хүргүүлнэ.

2.1 Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэж холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэн хариу өгч, тайлан мэдээг Маягт-ЗУГ-3 хүснэгтийн дагуу улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид цахимаар ирүүлнэ.

Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж тайлан мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэж, 1, 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

2.2 Төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын Ёс зүйн албаны ажлын тайлан мэдээг Маягт-ЗУГ-4 хүснэгтийн дагуу улирал, хагас, бүтэн жилээр сүүлийн сарын ажлын сүүлийн өдөр Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид цахимаар болон албан бичгээр ирүүлнэ.

2.3 Хүний нөөцийн дэлгэрэнгүй мэдээг Маягт-ХНС-1 мэдээг 6, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор албан бичиг /маш нууц/-ээр Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид ирүүлнэ.

2.4 Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2, 3, 4 дэх хавсралтын дагуу 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Бодлого зохицуулалт, хамтын ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид албан бичгээр болон цахимаар хүргүүлнэ.

Бодлого зохицуулалт, хамтын ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж жилийн тайлан мэдээг нэгтгэн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хүргүүлнэ.

2.5 Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр 6 дугаар сарын 10, бүтэн жилээр 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Бодлого зохицуулалт хамтын ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид албан бичгээр болон цахимаар хүргүүлнэ.

Бодлого зохицуулалт хамтын ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж жилийн тайлан мэдээг нэгтгэн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хүргүүлнэ.

2.6 Төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5 дугаар хавсралтын дагуу Бодлого зохицуулалт, хамтын ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ.

Бодлого зохицуулалт, хамтын ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж тайлан мэдээг нэгтгэн боловсруулж, дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хяналт, шинжилгээ үнэлгээ хийлгэхээр Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хүргүүлнэ. Тус газраас хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, хэлэлцүүлэн Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

2.7 Сургалтын тайлан мэдээг Улсын алба, аймаг, нийслэл, сум дүүрэг, баг хороо, аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд зохион байгуулсан гамшгаас хамгаалах ангиллын сургалтын мэдээг Маягт-СМ-1 маягтаар дэлгэрэнгүй тайлангийн хамт цахим хэлбэрээр Гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид, бие бүрэлдэхүүний сургалтын мэдээг Маягт-СМ-2 маягтын дагуу Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид тус тус улирал бүрийн сүүлийн сарын 10-ны өдөр, 6 ба 12 дугаар сарын 05-ны өдрөөр тасалбар болгож, 20-ны өдрийн дотор дэлгэрэнгүй тайлангийн хамт цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.8 Төв, орон нутгийн Онцгой байдлын анги байгууллагууд гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдлыг тухай бүр Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 22 дугаар тушаалаар батлагдсан “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний маягт”-ын дагуу бүртгэн авч, цахим бүртгэл мэдээллийн системд зааврын дагуу оруулна. Үүнд:

а. Бүртгэлийн маягтыг дуудлага хүлээн авсан шуурхай удирдлагын оператор, тус тохиолдол дээр ажилласан салаа, бүлгийн дарга болон тухайн орон нутгийн төрийн захиргааны байгууллага, Засаг дарга эсхүл тухайн шатны онцгой комисс, холбогдох салбарын яамнаас томилсон шуурхай бүлэг, ажлын хэсэг тухай бүр хөтөлж, шуурхай удирдлагын оператор цахим бүртгэл мэдээллийн системд оруулна.

б. Төв, орон нутгийн Онцгой байдлын анги байгууллагын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, гал түймрийн улсын хяналтын байцаагч цахим бүртгэл мэдээллийн системд оруулсан мэдээллийг хянаж баталгаажуулан, 48 цагийн дотор бүсийн төвийн дүн бүртгэл хариуцсан мэргэжилтэнд шилжүүлнэ.

в. Бүсийн төвийн дүн бүртгэл хариуцсан мэргэжилтэн цахим бүртгэл мэдээллийн системд оруулсан бүртгэлийг хянаж баталгаажуулан, Онцгой байдлын байгууллагын статистик, дүн бүртгэл хариуцсан нэгжид цахимаар шилжүүлнэ.

2.9 Бүсийн төвүүд тухайн бүсэд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын сарын мэдээг тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон Маягт-ГМ-1 хүснэгтийн дагуу өссөн дүнгээр гаргаж, дараа сарын 3-ны өдрийн дотор Үндэсний гамшиг, аюулт үзэгдэл, ослын хохирлын нэгдсэн системд оруулж, Онцгой байдлын байгууллагын статистик, дүн бүртгэл хариуцсан нэгжид ирүүлнэ.

2.10 Онцгой байдлын байгууллагын статистик, дүн бүртгэл хариуцсан нэгжид журмын 2.11-т заасан төв, орон нутгийн байгууллагаас ирүүлсэн нэгдсэн мэдээг нэгтгэж, сар бүрийн 5-ны өдрийн дотор Үндэсний статистикийн хороо, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус цахим хэлбэрээр хүргүүлнэ

2.11 Гал түймэр унтраах аврах ангийн хүчин чадлын мэдээг 7 хоног бүрийн Даваа гарагт, шифрийн мэдээг цахим бүртгэл мэдээллийн нэгдсэн системийн хүч хэрэгсэл, шифрийн мэдээ хэсэгт, сар, улирлын ажлын тайлан, мэдээг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгож дараа сарын ажлын эхний өдөр, 12 сарын мэдээг 16-ны өдөр цахим хэлбэрээр, хагас, бүтэн жилийн ажлын тайлан мэдээ, нэгдсэн удирдамжит арга хэмжээний тайланг заасан хугацаанд албан бичгээр, хүний амь нас хохирсон, 2 ба түүнээс дээш тасаг, 1 цагаас дээш хугацаанд үргэлжилсэн объектын гал түймрийн мэдээг тухай бүр нь Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид ирүүлнэ.

2.12 Төв, орон нутгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын байцаагч нь Ой, хээрийн түймэр гарсан тухай бүр Маягт-ОХ-1-г хөтөлж Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид ирүүлнэ.

2.13 Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагаас Холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны тайлан мэдээг Гамшгийн шуурхай удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид улирал бүрийн сүүлийн сарын 2 өдрийн дотор Маягт-ХМ-1 цахимаар ирүүлнэ.

2.14 Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар батлагдсан загварын дагуу хагас бүтэн жилээр сүүлийн сарын 20-ны өдрийн дотор Гамшгийн эрсдэлийн удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид цахимаар ирүүлнэ.

2.15 Гамшгийн голомтод ажилласан алба хаагчдын томилолт, урамшууллын тооцоо, холбогдох материалыг Маягт-СХ-1-ийн дагуу эхний хагас жилээр 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор, сүүлийн хагас жилээр 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Онцгой комиссын ажлын албанд албан бичгээр хүргүүлнэ. Гамшгийн голомтод ажилласан албан хаагчдын томилолт, урамшууллын тооцоо, холбогдох материалыг Санхүү, хангалт, хөрөнгө оруулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж нэгтгэн хянаж, Засгийн газарт хүргүүлнэ.

2.16 Төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон нэмэлт төсвийн гүйцэтгэлийн мэдээг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан маягт НТГ№2-ын дагуу гаргаж дараа сарын 05-ны өдрийн дотор Санхүү, хангалт, хөрөнгө оруулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид ирүүлнэ.

2.17 Санхүүгийн хугацаат тайлан, мэдээг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, Сангийн сайдын 2002 оны 144, 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргаж Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, хангалт, хөрөнгө оруулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид ирүүлнэ.

2.18 Төсвийн жилийн төсвийн төслөө удирдамжийн дагуу боловсруулж жил бүрийн 6 дугаар сарын 02-ны өдрийн дотор Санхүү, хангалт, хөрөнгө оруулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид албан бичгээр ирүүлнэ.

2.19 Төсвийн хуваарийн саналаа жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Санхүү, хангалт, хөрөнгө оруулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид албан бичгээр ирүүлнэ.

2.20 Улсын нөөцийн тайлан мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2010 оны 217 дугаар тушаалаар батлагдсан “Улсын нөөцийн бараа материал хүлээн авах, хадгалах, зарцуулах, тооллого явуулах журам”, “Улсын нөөцийн шатахууны агуулах, шатахуун сэлгэх станцад ээлж хүлээлцэх, тооллого хийх, тооцоо бодох журам”-нд заасны дагуу Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид ирүүлнэ.

2.21 Онцгой байдлын байгууллагын төв, орон нутаг дахь Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, салбарууд үйл ажиллагааны хагас жил, жилийн эцсийн тайланг 6 ба 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид ирүүлнэ.

Тайлангийн бүтэц:

- Удирдлага зохион байгуулалт
- Улсын нөөцийн бараа, материалын бүрдүүлэлт
- Улсын нөөцийн бараа, материалын зарцуулалт, сэлгэлт, шинэчлэлт
- Улсын нөөцийн бараа, материалын хадгалалт, хамгаалалт
- Агуулах, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ
- Авлага барагдуулалт
- Бусад

Гурав. Тайланг үнэлэх, дүгнэх

3.1 Төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагын Шуурхай удирдлагын операторуудын үйл ажиллагааг Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж Хавсралт №1 хүснэгтийн дагуу үнэлж, улирал бүр үнэлж дүгнэнэ.

3.2 Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг Гамшгийн шуурхай удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид нэгтгэж Хавсралт №2 хүснэгтээр улирал бүр үнэлж дүгнэнэ.

3.3 Гал түймэртэй тэмцэх газраас төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дүнг үнэлэхдээ Гал түймэр унтраах, аврах ангиудын сарын шифрийн мэдээг үндэслэн хавсралт №3 аргачлалаар нэгтгэж дүгнэнэ.

3.4 Онцгой байдлын байгууллагын төв, орон нутаг дахь Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, салбарын үйл ажиллагааг журмын 2.19-д заасан тайлан мэдээг Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж хавсралт №4 хүснэгтийн дагуу нэгтгэж дүгнэнэ.

3.5 Бие бүрэлдэхүүний сургалтын тайлан мэдээг Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж хавсралт 5-д заасан хүснэгтийн дагуу нэгтгэж дүгнэнэ.

3.6 Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага болон Улсын нөөц, хүмүүнлэгийн анги, салбаруудын санхүүгийн үйл ажиллагааг холбогдох хуульд заасан тайлан мэдээний маягтын дагуу гаргаж ирүүлснийг Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж хавсралт 6-д заасан хүснэгтийн дагуу нэгтгэж дүгнэнэ.

3.7 Онцгой байдлын ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулна.

Дөрөв. Хяналт тавих, хариуцлага тооцох

4.1 Тайлан мэдээг ирүүлэх, түүний үнэн зөв байдалд төв, орон нутгийн Онцгой байдлыг газрын дарга, захирагч нар хяналт тавина.

4.2 Энэ журмыг зөрчсөн, хэрэгжилтийг зохион байгуулаагүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Онцгой байдлын байгууллагын албан хаагчийн сахилгын дүрэмд заасны дагуу тухай бүр сахилгын шийтгэл ногдуулан, зөрчил дутагдлыг дахин давтахгүй байх арга хэмжээг зохион байгуулна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТӨВ ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГААС
ТАЙЛАН МЭДЭЭ АВАХ МАЯГТЫН ТОВЧОО

Д/д	Код	Мэдээ, тайлангийн нэр	Хугацаа	Мэдээний маягт	Мэдээ хүлээн авагч
0	1	2	3	4	5
1	ЗУГ	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн мэдээ	Улирал, хагас, жилээр сүүлийн сарын 15-ны өдөр, жилийн эцсийн биелэлтийг 12 сарын 15-ны дотор цахим болон албан бичгээр	ЗГХЭГ-ын даргын 2019 оны 47 тоот тушаалын 9 дүгээр хавсралтаар	Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж
2	ЗУГ	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ	Хагас, бүтэн жилээр сүүлийн сарын 15-ны дотор цахимаар	Маягт-ЗУГ-1	
3	ЗУГ	Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүд сарын ажлын тайлан мэдээг	Сар бүрийн 28-ны өдөр цахим болон албан бичгээр	Маягт-ЗУГ-2	
4	ЗУГ	Өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн мэдээ	Улирал бүрийн сүүлийн сарын 25 ны дотор цахимаар	Маягт-ЗУГ-3	
5	ЗУГ	Ёс зүйн албаны мэдээ	Улирал, хагас, бүтэн жилээр сүүлийн сарын ажлын сүүлийн өдрийн дотор цахимаар	Маягт-ЗУГ-4	
7	ХНС	Хүний нөөцийн дэлгэрэнгүй мэдээ	Хагас, бүтэн жилээр 06, 12-р сарын 15-ны дотор албан бичгээр /маш нууц/-ээр	Маягт ХНС-1	
8	СМ	Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын мэдээ	Улирал бүрийн сүүлийн сарын 10 болон 6 ба 12 дугаар сарын 5-наар тасалбар болгож, тасалбар болгосон өдрөөс хойш 5 хоногийн дотор хүснэгт, дэлгэрэнгүй тайлангийн хамт цахим хэлбэрээр	Маягт-СМ-1	
9	СМ	Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний сургалтын мэдээ		Маягт-СМ-2	Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ ТЕХНИКИЙН ХОЛБОГДОЛТОЙ ОСЛЫН МЭДЭЭ

10	ГМ	Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нэгдсэн мэдээ	Өссөн дүнгээр тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 3-ны дотор	Маягт-ГМ-1	Статистик, дүн бүртгэл хариуцсан нэгжид
12	ОХ	Ой хээрийн түймрийн мэдээ	Ой хээрийн түймэр гарсан тухай бүр	Маягт-ОХ-1	Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж
14	СХ	Гамшгийн голомтод ажилласан албан хаагчдын томилолт, урамшууллын тооцоо	5 дугаар сарын 15, 12 дугаар сарын 1 ны дотор	Маягт-СХ-1	Санхүү, хангалт, хөрөнгө оруулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж

.....
/Байгууллагын нэр/

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
/..... оны хагас, бүтэн жилийн байдлаар/

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
Нэг. Монгол Улсын Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр					
Хоёр. Шадар сайдын тушаал, шийдвэр					
Гурав. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал, албан даалгавар					
Дөрөв. Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэр					

Жич: Дээрх тайлан, мэдээнд аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гаргасан шийдвэр болон Улсын Онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг оруулахгүй болно.

Тайлан баталгаажуулсан:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг)

Тэмдэг

Тайлан нэгтгэсэн:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг)

..... ГАЗРЫН 2020 ОНЫ
.....ДҮГЭЭР САРЫН ТАЙЛАН

Он сар өдөр

.....хот/ аймаг

д/д	Хийгдсэн ажил	Төрөл	Чиглэл
1.		Салбарын хүрээнд хийгдсэн ажил	Салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах
2.			
3.			
4.			

Тайлбар:

САРЫН АЖЛЫН ТӨРӨЛД:

Тулгамдсан болон хоцорч буй ажил, Шинэлэг ажил, УИХ, ЗГ-т өргөн барьсан ажил, Салбарын хүрээнд хийгдсэн ажил, Хариуцлага, хяналт, хэрэгжилт цахим хуралд оруулах мэдээлэл.

САРЫН АЖЛЫН ЧИГЛЭЛД:

Салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Салбарын бодлого, төлөвлөлтийг сайжруулах, Салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр, Дотоод ажлын хүрээнд, ЗГ-ын үйл ажиллагааны хэрэгжилтийг хэрэгжүүлэх чиглэлээр зэрэг сонголтуудаас хамаарах төрөл, чиглэлийг сонгоно.

МЭДЭЭ ГАРГАСАН,

.....
(албан тушаал)

..... /...../
(гарын үсэг)

.....
/Байгууллагын нэр/

20... ОНЫ ... ДУГААР УЛИРАЛД ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ МЭДЭЭ

Он сар өдөр

.....хот/ аймаг

Үзүүлэлтүүд		Үзүүлэлтийн дугаар	Нийт дүн
Улиралд хүлээн авсан	Амаар		
	Бичгээр		
	Бүгд		
Үүнээс	Байгууллага /албан тушаалтан/ өөрөө зохих шийдвэр гаргаж хариу өгсөн		
	Шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад шилжүүлсэн		
	Ямар нэгэн шийдвэр гаргаж хариу өгч чадаагүй үлдсэн		
Шийдвэрлэж хариу өгсөн /шилжүүлсэн хугацаа/	Хуульд заасан хугацаанд шийдсэн /шилжүүлсэн/		
	Хуульд заасан хугацааг хэтрүүлж шийдсэн		
	Шийдэх хугацаа болоогүй хяналтын шатандаа байгаа		
Өргөдөл гомдол гаргагчийн бүрэлдэхүүн	Байгууллагын ажилтан, алба хаагч, сонсогч		
	Иргэн		

ХЯНАСАН,

.....
(албан тушаал)

..... /...../
(гарын үсэг)

Тэмдэг

МЭДЭЭ ГАРГАСАН,

.....
(албан тушаал)

..... /...../
(гарын үсэг)

..... ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН АЛБАНЫ
..... ОНЫ ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

20.....

.....

ХОТ

1. Ёс зүйн албаны үйл ажиллагаа			Оноо /0-100/
1.	Ёс зүйн албаны хурал зохион байгуулсан. /сар бүр/		
2.	Сахилгын талон цоолсон /сар бүр/		
3.	Дотоодын хяналт шалгалт /сар бүр/		
4.	Эрх зүйн мэдээлэл /сар бүр/		
5.	Сэдэвт аян /сар бүр/		
6.	Үр дүн		
2. Соёл хүмүүжлийн ажил			
7.	Соёл хүмүүжил, ёс зүйн сургалт, лекц яриа /сар бүр/		
8.	Сахилгын зөвлөгөөн /улирал бүр/		
9.	Спортын арга хэмжээ /сар бүр/		
10.	Соёл, урлагийн арга хэмжээ.		
11.	Нэгдсэн арга хэмжээ		
12.	Бусад арга хэмжээ		
13.	Үр дүн		
Гаргасан зөрчил, авсан арга хэмжээ			Тоо
14.	Ажил тасалсан	Сануулсан	
		Цалин хассан	
		Цол бууруулсан	
		Албан тушаалдаа дүүрэн тэнцэхгүйг сануулах	
		Халах	
15.	Нэгдсэн арга хэмжээ тасалсан	Сануулсан	
		Цалин хассан	
		Цол бууруулсан	
		Албан тушаалдаа дүүрэн тэнцэхгүйг сануулах	
		Халах	
16.	Үүрэг даалгавар биелүүлээгүй	Сануулсан	
		Цалин хассан	
		Цол бууруулсан	
		Албан тушаалдаа дүүрэн тэнцэхгүйг сануулах	
		Халах	
17.	Согтууруулах ундаа хэрэглэсэн	Сануулсан	
		Цалин хассан	
		Цол бууруулсан	

			Албан тушаалдаа дүүрэн тэнцэхгүйг сануулах	
			Халах	
18.	Сахилга ёс зүйн зөрчил		Сануулсан	
			Цалин хассан	
			Цол бууруулсан	
			Албан тушаалдаа дүүрэн тэнцэхгүйг сануулах	
			Халах	
19.	ОБА-ны дүрэм, журам зөрчсөн		Сануулсан	
			Цалин хассан	
			Цол бууруулсан	
			Албан тушаалдаа дүүрэн тэнцэхгүйг сануулах	
			Халах	
20.	Санал, дүгнэлт			

ЖИЧ: 1. Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор цахим болон албан бичгээр Захиргааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хүлээн авч нэгтгэн дүгнэх ба мэдээ ирүүлэх хугацаа, бодит байдлыг харгалзан 0-100 хүртэлх оноогоор дүгнэнэ. Хугацаа хэтэрсэн хоног тутам 10 оноо хасна.

2. Ёс зүйн албаны үйл ажиллагааг хурал зохион байгуулж, асуудлыг шийдвэрлэсэн байдал, дотоодын хяналт шалгалт, эрх зүйн мэдээлэл, сургалт, сэдэвт аян зохион байгуулсан байдлыг харгалзан 0-100 оноо өгнө. Шифрийн мэдээтэй зөрөх, бодит байдалд нийцээгүй, тоо баримтгүй, аливаа арга хэмжээг зохион байгуулаагүй тохиолдол бүр 10 оноо хасна.

3. Соёл хүмүүжил, ёс зүйн чиглэлээр сургалт, лекц яриаг сар бүр, сахилгын зөвлөгөөнийг улирал бүр хийсэн эсэх, нэгдсэн арга хэмжээ, албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх зорилгоор спорт, соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулсан байдлыг харгалзан 0-100 оноо өгнө. Шифрийн мэдээтэй зөрөх, бодит байдалд нийцээгүй, тоо баримтгүй, аливаа арга хэмжээг зохион байгуулаагүй тохиолдол бүрт 10 оноо хасна.

ТАНИЛЦСАН,

..... /...../

(албан тушаал)

Тэмдэг

(гарын үсэг)

ХЯНАСАН,

..... /...../

(албан тушаал)

(гарын үсэг)

ТАЙЛАН ГАРГАСАН,

..... /...../

(албан тушаал)

(гарын үсэг)

..... АЙМГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ ШИФРИЙН МЭДЭЭ

Он сар өдөр

.....хот/аймаг

төрөл			шифр	1-р улирал	2-р улирал	Хагас жилээр	3-р улирал	4-р улирал	Бүтэн жилээр
Нөхөн хангалтын мэдээ	Орон тоогоор		1						
	Одоо байгаа		2						
	Нөхөн хангалтын хувь		3						
	офицер	орон тоогоор		4					
		нөхөн хангагдсан	эр	5					
			эм	6					
		дутуу		7					
	Нөхөн хангалтын хувь		8						
	ахлагч	орон тоогоор		9					
		нөхөн хангагдсан	эр	10					
			эм	11					
		дутуу		12					
	Нөхөн хангалтын хувь		13						
	энгийн	орон тоогоор		14					
		нөхөн хангагдсан	эр	15					
			эм	16					
		дутуу		17					
	Нөхөн хангалтын хувь		18						
Цолны мэдээ	хурандаа	эр	19						
		эм	20						
	дэд хурандаа	эр	21						
		эм	22						
	хошууч	эр	23						
		эм	24						
	ахмад	эр	25						
		эм	26						
	ахлах дэслэгч	эр	27						
		эм	28						
	дэслэгч	эр	29						
		эм	30						
	Бүгд	эр	31						
		эм	32						
	ахлах ахлагч	эр	33						
		эм	34						
	ахлагч	эр	35						
		эм	36						
	дэд ахлагч	эр	37						
		эм	38						
Бүгд	эр	39							
	эм	40							

	Нийт төрийн тусгай		эр	41					
			эм	42					
Томилогдсон	Ахлагч /энгийн/-аас офицерийн бүрэлдэхүүнд			43					
	Сургууль төгссөн			44					
	Анхан шатны сургалт төгссөн			45					
	Бусад байгууллагаас			46					
	Бүгд			47					
Чөлөөлөгдсөн	Өөрийн хүсэлтээр			48					
	Сургуульд суралцахаар			49					
	Эрүүл мэндээр			50					
	Тэтгэвэрт гарсан			51					
	Шилжсэн			52					
	ОТЗБ-ын өөрчлөлтөөр			53					
	Нас барсан			54					
	Бүгд			55					
Сайшаал	Төрийн дээд одон, медаль	Үйлчилгээний гавьяат ажилтан		56					
		Цэргийн гавьяаны улаан тугийн одон		57					
		Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон		58					
		Цэргийн гавьяаны одон		59					
		Алтан гадас одон		60					
		Цэргийн хүндэт медаль		61					
		Хөдөлмөрийн хүндэт медаль		62					
		Шударга журам медаль		63					
	Шадар сайд	Тэргүүний ажилтан тэмдэг		64					
		Онц гал сөнөөгч тэмдэг		65					
	ОБЕГ-ын шагнал	Жуух бичиг		66					
		Баярын бичиг		67					
		Сайшаалын үнэмлэх		68					
		ОБА-ны төлөө		1	69				
		ОБА-ны төлөө		2	70				
		ОБА-ны төлөө		3	71				
	Иргэдийн хурал болон Засаг даргын шагнал			72					
	Анги байгууллагын шагнал			73					
	Бусад яам, агентлагийн шагнал			74					
	Бусад байгууллагын шагнал			75					
Бүгд			76						
Шийтгэл	Сахилгын шийтгэл	Сануулах		77					
		Цалингийн хувиар		78					
		А/Т-даа дүүрэн тэнцэхгүй байгааг сануулсан		79					
		Бүгд		80					
	Халагдсан	Удаа дараа албан үүргээ хангалтгүй биелүүлсэн		81					
		Олон хоног ажил тасалсан		82					
		А/Б-нд согтууруулах ундаа хэрэглэсэн		83					
		Гэмт хэрэг үйлдсэн		84					
	Бүгд		85						

Нийгмийн байдал	Орон сууцны нөхцөл	Тусламж	ТАТХ-иар мөнгөн тусламж	хүн	86						
				мян.төг	87						
			Дотоод журмаар	хүн	88						
				мян.төг	89						
			Эд материалын	хүн	90						
				мян.төг	91						
		Бүгд	хүн	92							
			мян.төг	93							
		Нийтийн орон сууц	Офицер	эр	94						
				эм	95						
ахлагч	эр		96								
	эм		97								
энгийн	эр		98								
	эм		99								
Бүгд		100									
Хашаа байшинд	Офицер	эр	101								
		эм	102								
	ахлагч	эр	103								
		эм	104								
	энгийн	эр	105								
		эм	106								
Бүгд		107									
Түрээсийн байранд	Офицер	эр	108								
		эм	109								
	ахлагч	эр	110								
		эм	111								
	энгийн	эр	112								
		эм	113								
Бүгд		114									
Айлд	Офицер	эр	115								
		эм	116								
	ахлагч	эр	117								
		эм	118								
	энгийн	эр	119								
		эм	120								
Бүгд		121									
Байгууллагын орон сууцанд	Офицер	эр	122								
		эм	123								
	ахлагч	эр	124								
		эм	125								
	энгийн	эр	126								
		эм	127								
Бүгд		128									
Амьжиргааны түвшин	Доогуур орлоготой	офицер	129								
		ахлагч	130								
		энгийн	131								
	Бүгд		132								
	Дундаж орлоготой	офицер	133								
		ахлагч	134								
энгийн		135									
Бүгд		136									
бүлийн	Гэр бүлгүй	Офицер	эр	137							
			эм	138							

Насны ангилал	Боловсролын түвшин	ахлагч	эр	139							
			эм	140							
			Бүгд		141						
		Өрх толгойлсон	Офицер	эр	142						
				эм	143						
			ахлагч	эр	144						
				эм	145						
			Бүгд		146						
		Гэр бүлтэй	Офицер	эр	147						
				эм	148						
			ахлагч	эр	149						
				эм	150						
			Бүгд		151						
